



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/361

Номгон

БНХАУ-ын Ганьсү мужийн албан төлөөлөгчдийг
Баянхонгор аймагт ажиллах үеэр хөрөнгө
зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр хэсгийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганьсү мужийн Жюцюань хотын хөдөө аж ахуйн салбарын албан төлөөлөгчид болон Жюцюань хотын Сүбэйгийн Монгол Үндэстний Өөртөө Засах Шиенийн соёл урлагийн салбарын албан төлөөлөгчдийн Баянхонгор аймагт хүрэлцэн ирж туршлага солилцох ажлыг үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын албан төлөөлөгчдийг Баянхонгор аймагт туршлага солилцон ажиллах үеэр Түйн голын эрэг орчмын хүлэмжийн аж ахуйд ажиллуулах, Жюцюань хотын хүлэмжийн аж ахуйн технологиос нутагшуулах, соёл урлагийн салбарын албан төлөөлөгчдийг Түүх угсаатны зүйн музей, Хөгжимт драмын театр туршлага судлан суралцах нөхцөл, боломжийг хөтөлбөрийн дагуу бүрэн бүрдүүлсүгэй.

3. Албан төлөөлөгчдийг Шивээ хүрэн боомтод угтан авах, тус боомтод үдэх, хүлээн авч уулзах, гарын бэлэг гардуулах болон аймагт туршлага солилцон суралцах хугацааны өдрийн хоолны зардлуудад 4,223,000 (Дөрвөн сая хоёр зуун хорин гурван мянган төгрөг)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.


4. Баянхонгор аймаг, Ганьсү муж хоорондын хөдөө аж ахуйн болон боловсрол, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааны эрчийг хадгалж, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын

641310935


2023 оны 07 сарын 09 өдөр

хэлтсийн дарга (П.Отгонбаяр), Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд Хотын Захирагч (Г.Энхбаяр) нарт даалгасугай.

5.Албан төлөөлөгчдийн туршлага солилцсон, туршлага судлан суралцсан тухай тайлан мэдээллийг хүлээн авч, үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 04-ний өдрийн 04/06/17 дугаар сарын 04-ний өдрийн 04/06/17 дугаар захирамжийн хавсралт



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ГАНБСҮ МУЖИЙН АЛБАН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БАЯНХОНГОР АЙМАГТ АЖИЛЛАСАН
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэрс	Хугацаа	Тооцоо	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Шатахуун	VI/10-17	2 машин 2 удаа 4000 км		2530	1850000
2	"TSE" ресторан	VI/10-17		21	45,000	945,000
3	"ЭНХ ЭРХЭТ АМГАЛАН" зоогийн газар	VI/10-17	өдөр, орой хоол	25	30,000	750,000
4	Дунд зах "Тамсаг"	VI/10,17	ус, ундаа	60	3800	228000
5	Дунд зах	VI/10,17	Гарын бэлэг	10	45000	450000
	НИЙТ ДҮН					4,223,000

оОо